

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.220.40; 47.080

Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн дэд бүтэц. Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн боомт. Ерөнхий шаардлага	MNS GOST R 57618-2:2023
Small craft infrastructure. Yacht harbours. General requirements	GOST R 57618-2:2017

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн С/03 дүгээр тушаалаар батлав.

Энэ стандарт нь 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандартаар бага оврын усан замын тээврийн хэрэгслийн боомтод тавих ерөнхий шаардлагыг тогтоосон.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд зөвхөн эш татсан хэвлэлийг хэрэглэнэ. Он заагаагүй эшлэлийн хувьд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ. Үүнд:

ГОСТ 12.1.004, Хөдөлмөрийн аюулгүй байдлын багц стандарт. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага;

ГОСТ 12.1.044, Хөдөлмөрийн аюулгүй байдлын багц стандарт. Бодис ба материалын шатах, тэсрэх дэлбэрэх аюул. Үзүүлэлтийн нэршил ба тэдгээрийг тодорхойлох аргачлал;

ГОСТ 12.3.003, Хөдөлмөрийн аюулгүй байдлын багц стандарт. Цахилгаан гагнуурын ажил. Аюулгүй байдалд тавих шаардлага;

ГОСТ 17.1.3.13, Байгаль хамгаалал. Усан мандал. Гадаргын усыг бохирдлоос хамгаалахад тавих ерөнхий шаардлага;

MNS 6314:2012, “Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хэрэглэх дохио тэмдэг, төрөл, загвар, нэр томьёо, тодорхойлолт, суурилуулах ба байрлуулах;

ГОСТ 26775 Дотоодын усан замын дээгүүр баригдсан гүүрний доогуур усан замын тээврийн хэрэгсэл нэвтрэн өнгөрөхөд зориулагдсан гарцын овор хэмжээ. Хэм хэмжээ ба техникийн шаардлага;

ГОСТ Р 12.4.026, Хөдөлмөрийн аюулгүй байдлын багц стандарт. Дохионы өнгө, аюулгүйн тэмдгүүд болон дохионы тэмдэглэгээ. Зориулалт ба хэрэглэх дүрэм. Техникийн ерөнхий шаардлага болон үзүүлэлтүүд. Турших арга;

MNS GOST R 57618-2:2023

ГОСТ Р 50597, Авто замууд ба гудамж. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцөлүүдээр зөвшөөрөгдсөн ашиглалтын байдалд тавих шаардлага. Хянах арга;

ГОСТ Р 55561-2013, Дотоодын усан замын тээвэр. Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн боомтын усны барилга байгууламжууд. Аюулгүй байдалд тавих шаардлага;

ГОСТ Р 56242, Дотоодын усан замын тээвэр. Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн боомтын усан орчин, түүний орц, гарц болон хөвөлтийн хязгаарлагдмал нөхцөл бүхий усан замын хэсэгт суурилуулсан лазерын чиглүүлэгч гэрэлт цамхаг. Ерөнхий шаардлага;

ГОСТ Р 1.2.032-1.001.16, Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн дэд бүтэц. Нийтлэг дүрмүүд;

ГОСТ Р 1.2.032-1.003.16, Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн дэд бүтэц. Засварын болон техник үйлчилгээний бааз. Ерөнхий шаардлага;

ГОСТ Р 1.2.032-1.004.16, Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн дэд бүтэц. Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн боомтын ашиглалт. Аюулгүй байдалд тавих шаардлага;

ГОСТ Р 1.2.032-1.005.16, Задгай усан орчин дахь амралт, зугаалга, соёл, спортын байгууламжууд, тэдгээрийн дэд бүтэц. Нэр томъёо ба тодорхойлолт;

СП 2.13130, Галын аюулаас хамгаалах систем. Хамгаалах объектуудын галд тэсвэртэй байдлыг хангах;

СП 3.13130, Галын аюулаас хамгаалах систем. Гал гарсан үед зарлан мэдээлэх болон хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх удирдлагын систем. Галын аюулгүй байдалд тавих шаардлага;

СП 5.13130, Галын аюулаас хамгаалах систем. Галын дохиолол болон автомат гал унтраагчийг суурилуулах. Хэм хэмжээ болон зураг төсөл боловсруулах дүрэм;

СП 31-102, Олон нийтийн үйлчилгээний барилга, байгууламжийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бусад хөдөлгөөний бэрхшээлтэй үйлчлүүлэгчдэд хүртээмжтэй байдалд тавих шаардлага;

СП 42.13330, Хот байгуулалт. Хот, хөдөөгийн суурин газрыг төлөвлөх, барилгажуулах. Шинэчлэгдсэн хувилбар СНиП 2.07.01-89;

СП 43.13330.2012, Үйлдвэрийн барилга, байгууламж. Шинэчлэгдсэн хувилбар СНиП 2.09.03-85.

ЖИЧ: Энэхүү стандартыг хэрэглэхдээ эшлэл болгож буй баримт бичгүүд нь хүчин төгөлдөр үйлчилж буй эсэхийг цахим сүлжээн дэх Оросын Холбооны Улсын Техникийн зохицуулалт, хэмжил зүйн Холбооны агентлагийн албан ёсны цахим хуудасны олон нийтээр ашиглах мэдээллийн систем, эсхүл тухайн жилийн 1 дүгээр сарын 01-ний байдлаар хэвлэгддэг “Үндэсний стандарт”-ын эмхэтгэл болон сар тутмын “Үндэсний стандарт”-ын лавлахаас шалгах нь зүйтэй юм. Хэрвээ огноо нь тавигдаагүй ишлэлд дурдсан баримт бичиг нь шинэчлэгдсэн бол тухайн баримт бичгийн хүчин төгөлдөр үйлчилж буй хувилбарыг, түүнд орсон бүх нэмэлт өөрчлөлтийг харгалзан ашиглахыг зөвлөж байна. Хэрвээ огноо нь тавигдсан ишлэлд дурдсан баримт бичиг нь шинэчлэгдсэн бол дээр

дурдсан тухайн баримт бичгийн батлагдсан (хүлээн зөвшөөрөгдсөн) онд гарсан хувилбарыг ашиглахыг зөвлөж байна.

3 Нэр томьёо ба тодорхойлолт

Энэхүү стандартад ГОСТ Р 57617-2017 (нэр томьёоны), ГОСТ Р 57618.1-2017, ГОСТ Р 57618.4-2017 (засварын бааз, үйлчилгээ, ерөнхий шаардлага) стандартуудад заасан нэр томьёо болон дараах тодорхойлолт бүхий нэр томьёог хэрэглэв. Үүнд:

3.1

барилга

барилга барих ажлын үр дүнд бий болсон, газрын дээрх болон газрын доорх хэсгээс бүрдсэн, дотроо өрөө тасалгаа, инженер-техникийн хангамжийн сүлжээ, инженер-техникийн хангамжийн системийг агуулсан, хүмүүс үйл ажиллагаа явуулахад болон үйлдвэрлэл байршуулах, ачаа бараа, материал хадгалахад зориулагдсан барилгын томоохон хэмжээний систем.

3.1.1

зогсоолын бетон хүзүүвч

(гуалин дүнзээр жааз зангидаж суурилуулан чулуугаар дүүргэж дээр нь бетон цутгасан хайрцаг): эргийн эгц, огцом налууг хашиж эргийг зогсоолын байгууламжтай холбож буй, тусад нь байгуулсан богино тавцант-зогсоолын хэсэг.

3.1.2

битүү агуулах

хашлага хана, дээврийн бүтэцтэй, өрөө тасалгаанаас бүрдсэн барилга эсхүл асар, эсхүл тийм барилга доторх өрөө тасалгаа.

3.1.3

задгай агуулах

битүү агуулах, эсхүл хур тунадас болон нарны туяанаас хамгаалагдсан хадгалах нөхцөлийг шаарддаггүй ачаа барааг хадгалахад зориулагдсан, орц, гарц, гэрэлтүүлэг бүхий зориулалтын тоног төхөөрөмжөөр тоногдсон бүтээлэгтэй талбай.

3.1.4

саравч

тулгуур багануудтай дээвэр, түүний доор байрлах талбай.

3.1.5

галын ослын зам

гал түймэр гарсан тохиолдолд гал унтраах машинууд явахад зориулагдсан тусгай зам.

3.1.6

бохир ус зайлуулах сүлжээ

бохир усыг цуглуулж, зайлуулахад зориулагдсан багц шугам хоолой, хуримтлуулагч, суваг болон тэдгээрийн дээр барьсан байгууламж.

3.1.7

гадаргуугийн ус

хур тунадас орох, цас хайлах, усалгаа хийх болон хатуу гадаргууг угааснаас үүссэн саарал ус.

3.1.8

цэвэрлэх байгууламж

бохир ус цэвэрлэхэд зориулагдсан байгууламж болон тоног төхөөрөмж.

4 Нийтлэг дүрэм

4.1.1 Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн боомт нь /цаашид “боомт” гэх/ эрэг орчмын нутаг дэвсгэрийн тусгайлан онцгойлсон хэсэг дээр болон уг нутаг дэвсгэртэй залгаа усан бүсэд усны объектын хэсэгт байрладаг. Боомтын бүтцийн бүдүүвч /схем/-ийг Хавсралт А-д харуулав.

4.1.2 Боомт нь бага оврын усан замын тээврийн хэрэгслийн бааз /флот/-д ГОСТ Р 57618.1-2017 стандартаар тавигддаг шаардлагууд болон энэхүү стандартын шаардлагыг хангасан байна.

4.1.3 Боомт нь хөдөлгүүртэй болон хөдөлгүүргүй дарвуулт завь, бусад бага оврын усан замын тээврийн хэрэгсэл, хөвөгч хэрэгслийн ашиглалтын хэвийн, аюулгүй байдлыг хэрэглэгчдийн идэвхтэй амралт зугаалга, спортын арга хэмжээ, аялал жуулчлалын үед хангах, түүнтэй уялдан гарах үйлчилгээг усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигчид, багийн гишүүд, зорчигчдод болон усны дэргэд амрах зугаалах сонирхолтой хүмүүст үзүүлэхэд зориулагдсан.

4.1.4 Боомтын зогсоолын байгууламжид дотоодын усан замын амралт зугаалгын усан замын тээврийн хэрэгсэл болон далай, тэнгисийн тойрон аяллын хөлөг онгоцнуудыг аргамжиж бэхлэх үед тухайн хөлөг онгоц, усан замын тээврийн хэрэгсэл тус бүрийн төрөл, ангилалд тохирсон тавих шаардлагыг зогсоолын байгууламжийн цогцолбор нь хангасан байна.

4.1.5 Боомтын технологийн цогцолбор, түүний дэд бүтцийг агуулсан боомтын үйл ажиллагааны бүдүүвч /схем/-ийг Хавсралт А-д харуулав.

4.1.6 Боомтын технологийн цогцолборт дараах объектууд орно. Үүнд:

4.1.6.1 усан замын зогсоолын байгууламжийн цогцолбор;

4.1.6.2 засвар үйлчилгээний цогцолбор;

4.1.6.3 техник, бусад үйлчилгээний цогцолбор;

4.1.6.4 багийн гишүүдэд үзүүлэх үйлчилгээний цогцолбор;

4.1.6.5 багийн гишүүд болон зорчигчдод үзүүлэх нэмэлт үйлчилгээний цогцолбор.

4.2

Багийн гишүүд болон зорчигчдод нэмэлт үйлчилгээ үзүүлэх цогцолбор дараах бүрдэлтэй байна. Үүнд:

4.2.1 амьдрах, амрах объект;

4.2.2 хоол, хүнсээр үйлчлэх объект;

4.2.3 гэрээгээр болон түрээсээр үйлчлэх усан замын тээврийн болон бусад хөвөгч хэрэгсэл;

4.2.4 боомтын үйлчилгээний усан замын тээврийн хэрэгслүүд;

4.2.5 усан замын тээврийн хэрэгсэл болон бусад хөвөгч хэрэгслийг жолоодож сургах сургалтын төв;

4.2.6 спорт-чийрэгжүүлэлт болон амралт зугаалгын цогцолбор;

4.2.7 автомашины зогсоолууд.

4.3 Технологийн цогцолборын дэд бүтцэд дараах объект орно. Үүнд:

4.3.1 хашлага хамгаалалтын болон эргийг хүчитгэж бэхжүүлсэн байгууламж;

4.3.2 албаны болон туслах барилга, байгууламж, тоног төхөөрөмж;

4.3.3 инженерийн шугам сүлжээ, харилцаа холбооны тоног төхөөрөмж, аюулгүй байдал, харуул хамгаалалтын төхөөрөмж хэрэгслүүд;

4.3.4 боомтод орох, гарах орц, гарцын авто зам;

4.3.5 боомтын үйлчилгээний усан замын тээврийн хэрэгслүүдэд зориулсан албаны болон туслах зогсоолын байгууламж;

4.3.6 ослын үед авран хамгаалах цогцолбор.

4.4 Боомтын технологийн цогцолборын аюулгүй байдал нь түүний бүрэлдэхүүнд орж буй бүх объектын аюулгүй байдал, тэдгээрийн ашиглалтын аюулгүй байдал нь ГОСТ Р 57618.3 стандартын шаардлагыг хангаж байгаа эсэх, гадаргын усыг бохирдлоос хамгаалах тухай ГОСТ 17.1.3.13 стандартад заасан “усан замын тээврийн хэрэгслүүд болон бусад хөвөгч хэрэгслүүдээс гадаргуугийн усанд бохир усаа асгах, хог хаягдал хаях, тээвэрлэж буй ачаагаа унагаах, түүнчлэн газрын тос, түүгээр үйлдвэрлэсэн шатахуун, тос тосон бүтээгдэхүүн асгахыг хориглоно” гэсэн шаардлагыг хангаж буй байдал, түүнчлэн боомтын технологийн цогцолборын дэд бүтцийн объектуудын аюулгүй байдлаар хангагдана.

4.5 Боомтын технологийн цогцолборын объектуудын ерөнхий үзүүлэлтүүд нь энэхүү стандартын шаардлагыг хангаж байх ба харин уг объектуудыг боомтын нутаг дэвсгэр болон усан бүсэд байршуулж зохион байгуулахдаа тэдгээрийг бие биедээ харилцан сөрөг нөлөөлөхгүйгээр байрлуулна.

4.6 Ашиглалтын баримт бичигт заасан шаардлагыг боомтод үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн ажилтнууд дагаж мөрдөж биелүүлсэн нөхцөлд боомтын технологийн цогцолборын объектууд болон тэдгээрийн бүрдэл хэсгүүд нь ашиглалтын (үйлчилгээний) бүх хугацааны туршид аюулгүй байдлын шаардлагыг хангаж байх ёстой.

4.7 Боомтын технологийн цогцолборын бүх объектын байршил, хийц бүтээц, төхөөрөмж хэрэгслийн тоноглол нь түүний эрчим хүчний үр ашигтай байдал болон экологийн аюулгүй байдлыг хангасан байна.

4.8 Объектуудын техникийн үзүүлэлтүүд болон хийц бүтээц нь тэдгээрийг ашиглах явцад хүрээлэн буй орчин, усан замын тээврийн хэрэгслүүд, багийн гишүүд, зорчигчид болон тэдний эд хөрөнгө, түүнчлэн боомтын үйл ажиллагааг зохицуулагч иргэн, хуулийн этгээдийн ажилтнуудад аюултай нөхцөл байдал үүсгэх эрсдэлийг хаасан, сэргийлсэн /минимум/ байна.

4.9 Боомтын захиргаа нь усан замын тээврийн хэрэгслийн зогсох газар, байршлыг заасан схем /бүдүүвч/ бүхий усан замын тээврийн хэрэгсэл боомтод зогсох дүрэм, зогсоолын байгууламжийг ашиглах, аюулгүй байдлыг нь хангах дүрэм, галын аюулгүй байдлын дүрэм болон боомтын нутаг дэвсгэр, усан бүсэд холбооны тусгай хэрэгсэл ашиглах дүрмийг тус тус боловсруулж батлан мөрдүүлнэ.

4.10 Боомтын захиргаа нь боомтын хил хязгаар болон түүнд орох, гарах үед баримтлах усан замын мэдээлэл, боомтын усан замын тээврийн хэрэгслийг хүлээн авах хэсгийн техникийн боломжийн талаарх мэдээлэл, боомтын газарчнаар зайлшгүй газарчлуулах бүсүүдийн талаарх мэдээлэл, навигацийн болон ус, цаг уурын нөхцөл байдлын талаарх мэдээллээр усан замын тээврийн хэрэгслийн багийг хангана.

5 Аюултай нөхцөл байдал, эрсдэлтэй бүс

5.1 Хүрээлэн буй орчинтой холбоотой аюултай нөхцөл байдал. Үүнд:

5.1.1 боомтын объектуудаас хүрээлэн буй орчинд үзүүлэх биологи, химийн болон физикийн шинж чанар бүхий аюултай болон хортой хүчин зүйлсийн нөлөөлөл;

5.1.2 боомтын технологийн цогцолбор дахь объектуудын техникийн байдалд нөлөөлж буй ус, цаг уурын нөхцөлийн өөрчлөлт.

5.2 Усан замын тээврийн хэрэгслүүд болон бусад тээврийн хэрэгслүүдтэй холбогдсон аюултай нөхцөл байдал. Үүнд:

5.2.1 усан замын тээврийн хэрэгсэл (бусад тээврийн хэрэгсэл) боомтын технологийн цогцолбортой шүргэлцэх, хавиралдах, мөргөлдсөнөөс (боомтын технологийн цогцолборын объектуудын үйл ажиллагаа доголдож ажиллагаагүй болсноос, боомтын технологийн цогцолборын объектуудын тээврийн хэрэгсэлтэй харилцан үйлчлэлд ордог үзүүлэлтүүд болон хийц бүтээцийг буруу сонгосны улмаас) эвдэрч гэмтэх;

5.2.2 боомтын объектууд усан замын тээврийн хэрэгсэл болон бусад тээврийн хэрэгсэлтэй шүргэлцэх, хавиралдах, мөргөлдсөнөөс (усан замын тээврийн хэрэгсэл, бусад тээврийн хэрэгслийн ажиллагаа доголдсоны улмаас, эсхүл тэдгээрийг удирдахдаа буруу арга барил хэрэглэсний улмаас) эвдэрч гэмтэх.

5.3 Усан замын тээврийн хэрэгслийн багийн гишүүд, зорчигчид, боомтод ажиллаж буй бусад хүмүүстэй холбоотой аюултай нөхцөл байдал. Үүнд:

5.3.1 барилга, байгууламж, тоног төхөөрөмж, өргөх-зөөвөрлөх машин механизм ба төхөөрөмж хэрэгслийн алдаатай буруу үзүүлэлтүүд болон хийц бүтээцийн алдаа доголдол эсхүл тэдгээрийн техникийн бүрэн бус байдлын улмаас хүмүүс бэртэж гэмтэх эсхүл эрүүл мэндэд нь хохирол учрах;

5.3.2 хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлгөөний хязгаарлалттай иргэдэд үйлчлэх үедээ урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйн улмаас хүмүүс бэртэж гэмтэх эсхүл эрүүл мэндэд нь хохирол учрах.

5.4 Боомтын объектуудыг ашиглагч байгууллагын ажилтнуудтай холбоотой аюултай нөхцөл байдал. Үүнд:

5.4.1 байгууламж, тоног төхөөрөмжийн хийц бүтээц болон үзүүлэлтийн буруу зөрүүгийн улмаас хүмүүс бэртэж гэмтэх эсхүл эрүүл мэндэд нь хохирол учрах;

5.4.2 өргөх-зөөвөрлөх машин механизм, тоног төхөөрөмжийн хийц бүтээц болон үзүүлэлтийн буруу зөрүүгийн улмаас хүмүүс бэртэж гэмтэх эсхүл эрүүл мэндэд нь хохирол учрах;

5.4.3 усан замын тээврийн хэрэгслийн хийц бүтээц болон үзүүлэлтийн буруу зөрүүгийн улмаас хүмүүс бэртэж гэмтэх эсхүл эрүүл мэндэд нь хохирол учрах.

5.5 Бодит аюултай хүчин зүйлс үйлчлэх бүсэд дараах бүс хамаарна. Үүнд:

5.5.1 боомтын нутаг дэвсгэрээр хийх бусад тээврийн хэрэгслийн болон боомтын усан бүсэд хийх усан замын тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний бүс;

5.5.2 машин механизм, тоног төхөөрөмж, эсхүл тэдний хэсгүүд, ажиллагааны эд ангиудыг шилжүүлэх хөдөлгөөний бүс;

5.5.3 усан замын тээврийн хэрэгслийн (түүнчлэн өргөгч төхөөрөмж /кран/ бүхий хөлөг онгоцны) хөдөлгөөний доор байрлах бүс;

5.5.4 тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, задалж салгах ажиллагаа явагдаж буй гадаргуу;

5.5.5 газар (усны түвшин, өрөөний шал, усан замын тээврийн хэрэгслийн тавцан)-ын гадаргуутай харьцуулахад харьцангуй өндөрт байрлах багийн гишүүд, боомтын бусад хүмүүсийн байршлын болон боомтын объектуудыг ашиглагч байгууллагын ажилтнуудын ажлын байрны бүс;

5.5.6 богино холбоо үүсэж хүн өртөж болзошгүй, хүний биед аюултай хүчдэл бүхий цахилгаан хэлхээ суурилуулсан бүс;

5.5.7 их хэмжээний чичиргээтэй бүс;

5.5.8 их хэмжээний дуу чимээтэй бүс;

5.5.9 их хэмжээний тоосжилттой эсхүл шатамхай хийтэй бүс;

5.5.10 ослын үед цацагдах шингэн бодис эсхүл халуун уураар хүмүүс түлэгдэж гэмтэж болзошгүй газрууд.

6 Боомтын усан бүс

6.1 Ерөнхий зүйл

6.1.1 Боомтын усан бүс нь усан замын тээврийн хэрэгсэл түр зогсож хүлээх хэсэг, усан замын зогсоолын байгууламжуудын усан бүс, усан замын тээврийн хэрэгсэлд цогц үйлчилгээ үзүүлэх байгууламж болон хэрэгслүүдийн усан бүс, усан замын тээврийн хэрэгсэл болон бусад хөвөгч хэрэгслийг усанд тавих, уснаас өргөж гаргахаар тусгайлан тоноглогдсон байршлын усан бүс, тэдгээрт нэвтрэх орц, гарцуудаас тус тус бүрдэнэ.

6.1.2 Боомтын усан бүс нь усан замын тээврийн хэрэгслийн нэвтрэн өнгөрөх гол замын хөдөлгөөний хил хязгаараас гадуур байрлана.

6.1.3 Боомтын усан бүст дараах шаардлагууд хангагдсан байна. Үүнд:

6.1.3.1 боомтын усан бүсийн хил хязгаарыг маш тодорхой тэмдэглэсэн байх;

6.1.3.2 боомтын усан бүсийн усны гүн нь хөвөлтийн улиралд усан замын тээврийн хэрэгсэл чөлөөтэй нэвтрэн орох, гарах нөхцөлийг хангаж байх;

6.1.3.3 боомтын усан бүсийн хил хязгаарын дотор усан замын тээврийн хэрэгслийн хөвөлт /навигаци/-ийн аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай – гол зам, усан замын тээврийн хэрэгсэл зогсож хүлээх хэсэг, усан замын зогсоол зэргийг нарийн тодорхой тэмдэглэсэн байна.

6.1.4 Боомтын усан бүс дэх хөвөгч зогсоолууд нь найдвартай бат бөх бэхлэгдсэн байх бөгөөд эрэг талаас түүнд дөхөж очих эсхүл Боомтын үйлчилгээний тээврийн хэрэгслээр хүрэлцэн очих нөхцөлийг бүрдүүлсэн байна.

6.1.5 Зогсоолуудын ойр орчимд болон тэдгээрийн усан бүсэд усан замын тээврийн хэрэгсэл эсхүл түүний цуваа эргэх үйлдэл хийх орон зай байхгүй тохиолдолд усны урсгал дагуу доошоо, эсхүл усны урсгалын дээд талд эргэлтийн манёвр хийх зориулалттай зогсох хэсгийг байгуулж болно.

6.1.6 Боомтын усан бүсийн усны гүн нь шаардлагатай тохиолдолд усан замын тээврийн хэрэгслүүд /флот/- ийн өвлийн сул зогсолтын нөхцөлд тохирсон байна.

6.1.7 Боомтын усан бүс, тухайн бүсэд зогсож буй усан замын тээврийн хэрэгслүүд, боомтын нутаг дэвсгэр, байгууламж зэргийг хүчтэй давлагаа, цөн түрэлт, үерийн ус, далайн шуурга, хүчтэй салхи, давлагааны үйлчлэлээс, усан замын тээврийн хэрэгслүүд, бусад хөвөгч хэрэгслүүдийг дайвалзал, налалт, цохилтоос болон усан дээр хөвж буй эд зүйлстэй мөргөлдөх аюул ослоос тус тус хамгаалах, түүнчлэн боомтын усан бүсийг элс, шаварт автагдах эрсдэлийг багасгах зорилгоор хашлаганы байгууламж (овоолсон далан, чулуун далан, давлагаа сааруулагч, мөс зүсэгч) барьж байгуулж болно.

6.1.8 Хамгаалалтгүй усан орчинд үүсдэг давлагааны жилийн дундаж хэвийн өндөр нь 0,3 м-ээс их байх тохиолдолд давлагаанаас хамгаалах байгууламж барьж байгуулж болно.

6.1.9 Усан замын зогсоолыг давлагаа, салхинаас хамгаалахын тулд давлагаа сааруулагч ашиглана.

6.1.10 Давлагаа сааруулагчийн төрлийг сонгохдоо тухайн бүс дэх давлагааны түрлэгийн алслах зай, салхины болон давлагааны нөхцөл байдал, эргийн шугамын тогтцыг харгалзан үзнэ.

6.1.11 Давлагаанаас хамгаалах үндсэн аргууд. Үүнд:

6.1.11.1 байгалийн чулуу, буталсан чулуу эсхүл тусгайлан бэлтгэсэн төмөрбетон блок (тетраэдр)-оор овоолсон далан хэлбэртэй давлагаа сааруулагч байгуулах, ийм тохиолдолд далангийн өндөр нь хамгийн өндөр давлагаанаас нэг метрээс дээш өндөр байх ёстой;

6.1.11.2 хүнд төмөрбетон понтон /хөвөгч/ суурьтай хөвдөг давлагаа сааруулагч байгуулах;

6.1.11.3 дээд ирмэг нь хамгийн өндөр давлагааны шовх оройгоос дээш өндөрт, доод ирмэг нь давлагааны хамгийн нам цэгээс доош өндөрт байхаар тулгуур шонд бэхэлсэн бетон хавтангууд, модон самбар хаалтууд, төмөр хавтан г.м. бүх төрлийн материалаар хийсэн суурин /байнгын/ “хашаа” байгуулах;

6.1.11.4 нүхтэй самбар хавтан (эсхүл нягт нүхтэй сараалж тор)-г давлагааны хүчийг сааруулагч болгон ашиглах;

6.1.11.5 бетон эсхүл металл хийцтэй босоо хана.

Жишээ нь:

1) Овоолсон далан хэлбэртэй давлагаа сааруулагчийн дотор талд эрэг бэхэлсэн хана бүхий зогсоол, эсхүл эрэг дагуу далан гудамж байгуулж болно.

2) Хүнд төмөр бетон понтон /хөвөгч/ нь богино, нам давлагааг сааруулж, давлагааны өндрийг 80% хүртэл багасгах боловч хүчтэй, урт давлагааг төдийлөн сааруулж чаддаггүй бөгөөд давлагаанд түрэгдэн хөвөх талтай.

3) Бетон эсхүл металл хийцтэй цул хана нь буцаж ойсон давлагааг үүсгэдэг.

4) Зарим тохиолдолд үргэлжилсэн цуваа хамгаалалтыг, тухайлбал овоолсон далан болон хөвөгч понтон давлагаа сааруулагчийг хэрэглэх шаардлагатай.

6.2 Зогсоол орчмын усан бүс

6.2.1 Зогсоол орчмын усан бүс аюулгүй байх ёстой. Үүнд:

6.2.1.1 усан замын тээврийн хэрэгслийг зогсоолд зогсоох, уяж бэхлэх үед;

6.2.1.2 усан замын тээврийн хэрэгсэл зогсоолоос хөдлөх үед.

6.2.2 Зогсоол орчмын усан бүсийн урт нь үйлчлүүлэх усан замын тээврийн хэрэгслийн урт болон тэдгээрт үйлчлэх үйлчилгээний аргуудад нийцсэн байна.

6.2.3 Хоорондоо залгаа орших зогсоолуудын эргэн тойрны усан бүсийн эргэлтийн өнцөг нь усан замын тээврийн хэрэгслүүд зогсоолд зогсох, зогсоолоос хөдлөх үеийн аюулгүй байдлыг хангасан байна.

6.2.4 Зогсоол орчмын усан бүсийн өргөнийг усан замын тээврийн хэрэгсэл нэвтрэн өнгөрөх гол замын зах эсвэл усан замын орц, гарц хүртэл тодорхойлохдоо зогсоолуудын эрэгтэй харьцуулсан байрлал, усан замын тээврийн хэрэгсэл зогсоолоос хөдлөх үедээ эргэлт хийх зайлшгүй шаардлага, зогсоолуудын ойр орчимд зогсоол руу шахагч урсгал байгаа эсэх, усан замын тахиралдсан байдал зэргийг харгалзан үзэх шаардлагатай.

6.2.5 Усан замын тээврийн хэрэгсэл нь зогсоолоос хөдлөхдөө эргэх үйлдэл хийх зайлшгүй шаардлагатай, тусгай үндэслэл байгаа тохиолдолд усан замын тээврийн хэрэгсэл нэвтрэн өнгөрөх усан бүсэд эргэх үйлдэл хийхийг зөвшөөрнө.

6.2.6 Зогсоол орчмын усан бүсийн усны гүн нь усан замын тээврийн хэрэгсэл зогсоолд аюулгүй зогсох нөхцөлийг хангасан байх ба дараах зүйлийг тооцсон байна. Үүнд:

6.2.6.1 усан замын тээврийн хэрэгслийг даацынх нь хэмжээгээр бүрэн ачаалсан үеийн суулт;

6.2.6.2 усан замын тээврийн хэрэгслээс ачаа буулгах, ачаа ачихтай холбоотойгоор үүсэх, түүний хошуу болон сүүл хэсгийн суултын өөрчлөлт болон усан бүс дэх хог хаягдлыг тооцож усны гүнийг тогтоох;

6.2.6.3 давлагаатай үед усан замын тээврийн хэрэгсэл хайрдахгүй байхаар усны гүнийг тооцох;

6.2.6.4 хүчтэй салхины нөлөөгөөр усны түвшин өөрчлөгдөхийг тооцож усны гүнийг хангалттай байх;

6.2.6.5 усан замын тээврийн хэрэгслийн ёроолын усан доорх хөдөлгөөнийг тооцож усны гүнийг хангалттай байлгах.

6.3 Боомтод усаар нэвтрэх орц гарц

6.3.1 Боомтод усаар нэвтрэх орц гарц нь усан замын тээврийн хэрэгслүүд боомтоос нээлттэй усан зам руу орох гарах, нээлттэй усан замаас боомтод орох, гарахад ямар нэгэн саадгүй чөлөөтэй хөвөх боломжийг тэдэнд олгосон байна. Боомтод усаар нэвтрэх орц гарц нь хөвөлтийн улирлын туршид усан замын тээврийн хэрэгслүүд үйлчлүүлэх боломжтой, аюулгүй байна.

6.3.2 Боомтод усаар нэвтрэх орц гарц нь усан замын тээврийн хэрэгслүүдийн болон тэдгээрийн цувааны хоёр талын урсгалын хөдөлгөөнийг хангаж байх ёстой. Салаалах төхөөрөмжөөр тоноглол нэг урсгалтай болгохыг зөвшөөрч болно.

6.3.3 Усан замын тахиралдсан хэсгийн өргөнийг түүний шулуун хэсгийн өргөнтэй харьцуулж, түүний утгаар нэмэгдүүлж тооцно.

6.3.4 Боомтод нэвтрэх орц, гарц дахь гол усан замын усны мандал дээрх хэмжээ нь ГОСТ 26775 стандартын шаардлагыг хангасан байна.

6.3.5 Усан замын тэнхлэгээрээ дугуйрах, тахиралдах хамгийн бага радиус нь өөрөө явагч усан замын тээврийн хэрэгсэл, чирүүлж буй усан замын тээврийн хэрэгслийн

цуваан дахь хамгийн том оврын усан замын тээврийн хэрэгсэл болон түлхэгдэж буй усан замын тээврийн хэрэгслийн цуваа аюулгүй өнгөрөх байдлыг хангасан байна.

6.4 Хөвөлт /навигаци/-ийн орчны аюулгүйн нөхцөл байдал

6.4.1 Боомтын усан бүс дэх хөвөлт /навигаци/-ийн орчны аюулгүйн нөхцөл байдал нь усан замын тээврийн хэрэгслүүд хөвөхөд аюулгүй, саадгүй байх нөхцөлийг хангаж, усан замын зогсоол, гидротехникийн байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хэвээр хадгалах ёстой.

6.4.2 Хөвөлт /навигаци/-ийн орчны нөхцөл байдлыг илтгэж буй эргийн болон хөвөгч тэмдгүүд, түүнчлэн чиглүүлэгч гэрэлт цамхгийн үйл ажиллагааг хөвөлтийн улирлын турш хангасан байна.

6.4.3 Дотоодын усан замаар хөвөх хөвөлт /навигаци/-ийн нөхцөл байдлыг илтгэх бүх тэмдгүүд болон гэрэл дохионы хэлбэр, хэмжээ, өнгө, үзүүлэлтүүд нь MNS 6314:2012 “Усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хэрэглэх дохио тэмдэг, төрөл, загвар, нэр томьёо, тодорхойлолт, суурилуулах ба байрлуулах” стандартын шаардлагыг хангасан байна.

6.4.4 Боомтод усаар нэвтрэх орц, гарц нь чиглүүлэгч гэрэлт дохиотой байна.

6.4.5 Хаврын шар усны халиа болон үерийн үед усанд автагддаг хашлаганы байгууламжуудад усанд автагдах үед нь нөхцөл байдлыг нь илтгэсэн тэмдгүүдийг байрлуулна.

7 Боомтын нутаг дэвсгэр

7.1 Эрүүл ахуй, халдвар хамгааллын бүс

7.1.1 Боомт, түүний нутаг дэвсгэр дээрх объектууд нь эрүүл ахуй, халдвар хамгааллын бүстэй байна.

7.1.2 Боомт, түүний объектуудын эрүүл ахуй, халдвар хамгааллын бүсийг боомтын удирдлага тогтооно.

7.2 Боомтын нутаг дэвсгэрт тавих шаардлага

7.2.1 Боомтын нутаг дэвсгэрийг хаалт, хашаагаар тусгаарлаж хамгаалсан байна.

7.2.2 Боомтод орох хэсэгт дамжин өнгөрөх тасалгаатай байна.

7.2.3 Боомтын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл эргэх үйлдэл хийх талбайгүй байх тохиолдолд боомтод нэвтрэн орох хоёроос цөөнгүй хаалгыг төлөвлөсөн байна.

7.2.4 Боомтын нутаг дэвсгэрээс төрөл бүрийн тээврийн хэрэгсэл гарах, ороход зориулагдсан дэлгэгддэг хаалгыг дотогшоо нээгдэж байхаар, өөрөө аяндаа хаагдах боломжгүйгээр суурилуулна. Автомашин нэвтрэн ороход зориулагдсан хаалганы өргөнийг боомтын нутаг дэвсгэрт нэвтрэн орох хамгийн том оврын авто тээврийн хэрэгслийн өргөнтэй харьцуулж, дээр нь 1,5 м-ийг нэмж тооцох ба гэхдээ нийт өргөн нь 4,5 м-ээс багагүй байна.

7.2.5 Зогсоолын хязгаар дахь нутаг дэвсгэрийн тэмдэглэгээ нь усан замын зогсоолын зориулалт, залгаа орших нутаг дэвсгэрийн тогтоц, хэрэглэж буй технологийн тоног төхөөрөмж гэх мэтийг харгалзан тооцсон, боомтын эрэг дээрх объектуудыг усны болзошгүй бүх түвшин болон цөн түрэлтээс хамгаалсан аюулгүй байдлыг нь хангасан байна.

7.2.6 Усанд автаж болзошгүй талбайг хөвөлт /навигаци/ -ийн аюулгүй байдлыг хангах суурин эсхүл хөвөгч тэмдгүүдээр тоноглоно.

7.2.7 Боомтын нутаг дэвсгэрийн өргөнийг тодорхойлохдоо түүн дээр байгуулах төмөр зам болон краны зам, ачаа хадгалах агуулахын талбай, авто тээврийн хэрэгслээр зорчих замууд, авто тээврийн хэрэгсэл зогсох зогсоол болон манёвр хийх талбай, ачиж буулгах машин механизм, битүү агуулах, үйлдвэрлэлийн болон туслах барилгууд, зорчигчдод зориулсан барилгуудыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрүүл ахуй, галын аюулаас хамгаалах болон бусад стандарт, хэм хэмжээг сахин мөрдөж байрлуулах нөхцөлийг харгалзана.

7.2.8 Агуулахууд, ачаа хадгалсан талбай руу тээврийн хэрэгсэл ойртож дөхөхөд хялбар байхаар боомтын нутаг дэвсгэрийг төлөвлөнө.

7.2.9 Гадаргуугийн усыг зайлуулах зорилгоор боомтын нутаг дэвсгэрийг ус хүлээн авах эсхүл ус зайлуулах байгууламжийн зүгт налуу төлөвлөнө.

7.2.10 Боомтын нутаг дэвсгэр дээр байгаа техникийн зориулалтаар төлөвлөсөн нүх, суваг, шуудуу болон бусад хонхрууд нь бат бөх нягт, таглаа хаалттай эсхүл хашлагатай байна.

7.2.11 Нутаг дэвсгэр нь дээр, доор түвшинд байрладаг боомтуудад өндөр, нам /хоёр/ түвшинг хооронд нь холбосон налуу зам (пандус)-ын налуу нь авто эсхүл цахилгаан ачигч хэрэглэх үед болон авто тээврийн хэрэгслийн байнгын хөдөлгөөнтэй үед 60 промилле-ээс хэтрэхгүй байх ба байнгын бус хөдөлгөөнтэй үед зөвхөн авто тээврийн хэрэгсэлд зориулсан налууг 90 промилле -ээр нэмэгдүүлж болно.

7.2.12 Хэрэв зураг төсөлд өөрөөр урьдчилан заагаагүй бол гал унтраах арга хэмжээ авах болон гал унтраах машинууд боомтын усан бүсээс ус соруулж авах зорилгыг хангахын тулд усан бүс ба нутаг дэвсгэрийн заагт гал унтраах машинуудыг хялбар хүрч очих боломжийг хангасан байх шаардлагатай.

7.3 Боомтын технологийн цогцолборын барилга, байгууламжид тавих шаардлага

7.3.1 Үйлдвэрийн газруудын объектуудтай ижил төстэй боомтын объектууд (засвар үйлчилгээний газар, гараж, цахилгаан станц, уурын зуух, дотор болон гадна талбайн инженерийн хангамжийн шугам сүлжээ г.м.) нь хэрвээ эдгээр объектын тухайд энэхүү стандартаар тусгай нэмэлт шаардлагыг тавиагүй бол, барилгын зураг төсөл боловсруулахад тавих нормын шаардлагыг хангасан байна.

7.3.2 Ачаа баглах төхөөрөмж хэрэгсэл болон ачаа шилжүүлэн ачиж зөөвөрлөх тоног төхөөрөмж хэрэгслүүдийг хадгалах аж ахуйн өрөө, тасалгааг төлөвлөх зайлшгүй шаардлагатай.

7.3.3 Аж ахуйн өрөө, тасалгаа нь үйлдвэрлэлийн талбай, хэсгүүдэд аль болох ойрхон, халаалттай барилга дотор байрлана.

7.3.4 Ачаа ачиж, буулгах тоног төхөөрөмж хадгалах өрөө, тасалгаанд төрөл бүрийн ачаа баглах төхөөрөмж хэрэгслийг хадгалах тусгай тасаг болон тавиур, үүрүүдийг төлөвлөсөн байна.

7.3.5 Ачаа баглах том оврын төхөөрөмж, хэрэгслийг хадгалахад зориулж тусгайлан зассан задгай талбайг төлөвлөнө.

7.3.6 Засвар механикийн газрын галын болон тэсэрч дэлбэрэх аюултай өрөө, тасалгаануудыг хүнд, зузаан даацын ханаар тусгаарлана.

7.3.7 Засвар механикийн газрын хаалгыг дулаан хадгалах унжуурган хөшгөөр тоноглогсон байна.

7.3.8 Засвар механикийн газрын болон орчны задгай талбай нь хатуу хучилттай байна.

7.3.9 Галын дохиолол өгөх болон галын аюулыг зарлан мэдээлэх систем нь MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага болон "Барилга, байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл" /БНБД 21-04-05/ барилгын норм ба дүрэмд заасан шаардлагыг хангасан байна.

7.3.10 Технологийн цогцолборын барилгуудын халаалтын системүүдийг ажлын бус цагаар дулааны урсгалыг багасгаж бууруулдаг системээр тоноглоно.

7.4 Усан замын тээврийн хэрэгслийн зогсоолын байгууламжид тавих шаардлага

7.4.1 Зогсоолын байгууламж нь эргийн болон хөвөгч байна.

7.4.2 Зогсоолын байгууламжийн хийц бүтээц, тоног төхөөрөмж, тэдгээрт үзүүлэх ачаалал нь ГОСТ Р 55561 стандартад заасан боомтын усны барилга байгууламжид тавигддаг аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

7.4.3 Хөвөгч зогсоолыг усны ёроолтой харьцангуй тохирох газарт тогтоож бэхэлсэн байна.

7.4.4 Зогсоолын хэмжээ, усан замын тээврийн хэрэгслийн усны мандлаас дээш орших хана (борт)-ын өндөр, хийц бүтээц, бат бөх байдал, усан түрцийг тухайн зогсоолд үйлчлүүлэх усан замын тээврийн хэрэгслийн төрлүүд болон тэдгээрийн зогсох байршлыг харгалзан тогтооно.

7.4.5 Усан замын тээврийн хэрэгслийн зогсох байршлын хувилбарууд. Үүнд:

7.4.5.1 зогсоолд хажуу хана (борт)-аараа налж зогсох;

7.4.5.2 зогсоолд хойд талаараа эсвэл хамраараа тулж өнцөг гарган зогсох.

7.4.6 Зогсоолын урт нь усан замын тээврийн хэрэгсэл зогсоолд аюулгүйгээр орж зогсох, зогсоолоос хөдлөх үед болон хүмүүсийг буулгах, суулгах үед аюулгүй байдлыг хангасан байна. Зогсоолын уртыг, зогсоолуудын хил хязгаар хооронд, усан бүс ба нутаг дэвсгэр хоорондын заагийн дагуу хэмжиж тодорхойлно.

7.4.7 Зогсоолын байгууламж (зогсоолын хана, хүзүүвч тулгуурууд, шонгууд) - ийн уртыг тооцоолохдоо түүний дээр аргамж, бэхэлгээний болон мөргөлт, цохилтын хүчийг сааруулах зөөлөвч резин хаалт тоноглол хэрэгслийг байрлуулах шаардлагыг харгалзан үзэх шаардлагатай.

7.4.8 Хүзүүвч болон тулгуур шон хэлбэрээр байгуулсан зогсоолын байгууламжийн хувьд хүзүүвч эсхүл тулгуур шонгуудын хооронд байх шаардлагатай зайг ГОСТ Р 55561-2013 стандартын 6.4.6 -д “ачааны зогсоол нь өндрөөсөө үл хамааран ирмэгээсээ 20см-ээс багагүй өндөртэй цохилт бууруулагч дугуйнууд болон 1,1 м өндөртэй сугалж авч болдог явган хашлагатай байна. Зорчигчдын зогсоол нь ирмэгийн шугамаас 1,5-2,0м зайтай байрлах 1,1м-ийн өндөртэй явган зорчигч барьж явах хашлагатай байна. Эрэг дээр гарах хүзүүвч болон дамжин өнгөрөх гүүр нь мөн 1,1м-ийн өндөртэй явган хүний хашлагатай байна” гэж тус тус заасны дагуу авна. Богино хугацаагаар ашиглах зогсоолын хувьд усан замын тээврийн хэрэгслийн уртын 2/3-тай тэнцүү хэмжээнээс, зогсоолын нүүрэн талын нийт уртын дагуух хүзүүвч эсвэл тулгуур шонгийн өргөнийг хоёр дахин ихэсгэсэн өргөнийг хасаж тооцсон хэмжээгээр хүзүүвч ба тулгуур шонгуудын хоорондох зайг нэмэгдүүлж болно.

7.4.9 Усан замын тээврийн хэрэгслийг зогсоолд аргамжиж бэхлэхэд зориулагдсан тоноглол хэрэгслийг ГОСТ Р 55561-2013 стандартын 6.4.8-д “ачааны зогсоол болон зогсоолын байгууламжид усан замын тээврийн хэрэгслийн зогсож болох хамгийн бага гүнийг тэмдэглэсэн тэмдэглэгээнээс дээшээ 6м-ээс илүүгүй өндөрт, ирмэг дээр нэг эгнээнд аргамжааны шонгуудыг, харин тэдгээрийн доод талыг хонхойлж 1,5-2,0м-ийн алхамтай, гайк хэлбэрийн аргамжааны цагаригуудыг суурилуулна” гэж заасны дагуу байрлуулна. Аргамжиж бэхлэх хамгийн захын тоноглол хэрэгслийг бетондож хүчитгэсэн эргийн төгсгөлд аль болох ойрхон суурилуулна.

7.4.10 Зогсоолыг хамгаалалтын хучилт эсхүл усан замын тээврийн хэрэгслийг цохигдож гэмтэхээс хамгаалах зөөлөвч резин хаалт хэрэгслээр тоноглоно.

7.4.11 Усан замын тээврийн хэрэгслийг цохигдож гэмтэхээс хамгаалсан зөөлөвч резин хаалт хэрэгслийн хийц бүтээц нь усны түвшний хэлбэлзэлтэй холбогдон усан замын тээврийн хэрэгслийн хажуу ханын өндөр өөрчлөгдөх үед түүний хажуу талын ханыг хамгаалсан урт нарийн модон жийргэвчид тээглэж гацахгүйгээр зохион бүтээгдсэн байна.

7.4.12 Хөвдөг зогсоолуудыг өргөгддөг тавцан, гүүрэн гарц, урсдаг шатны тусламжтайгаар эрэгт холбоно.

7.4.13 Хүмүүс зорчих боломжтой бүх гадаргуу нь халтирдаггүй байх ёстой.

7.5 Усан замын тээврийн хэрэгслийн эрэг дээрх зогсоол

7.5.1 Усан замын тээврийн хэрэгсэлд зориулсан эрэг дээрх зогсоолыг задгай талбайд, саравч доор, халаалтгүй эсхүл халаалттай засвар үйлчилгээний байгууламж дотор байгуулна.

7.5.2 Задгай талбай дээрх зогсоолын эгнээ хооронд бүх төрлийн усан замын тээврийн хэрэгслийг зогсох байршилд нь оруулах, гаргахтай холбогдсон маневр хийх болон тэдгээрийг тээвэрлэх, зөөвөрлөхөд зориулсан хангалттай зай бүхий тээврийн хэрэгсэл зорчих замтай байна.

7.5.3 Задгай талбай дээрх зогсоолын эгнээ хоорондох тээврийн хэрэгсэл зорчих зам нь хатуу хучилттай байна.

7.5.4 Задгай талбай дээрх зогсоолд зогсох байршлыг усан замын тээврийн хэрэгслийн овор хэмжээгээр бүлэглэнэ.

7.5.5 Зогсох байршил тус бүрийн хоорондох зай нь усан замын тээврийн хэрэгсэл дээр авиран гарах шатны зайг тооцон, хүн дурын усан замын тээврийн хэрэгслийг тойрон гарах боломжтой байна.

7.5.6 Задгай талбайд цахилгааны болон усны шугамын холболт хийгдсэн, гал унтраах хэрэгслүүд болон галын ослын замыг төлөвлөсөн байна.

7.5.7 Дулаалгагүй засвар үйлчилгээний байгууламж нь бүх талаасаа хаалттай, цаг агаарын нөлөөллөөс хамгаалагдсан өрөө тасалгаа байна.

7.5.8 Дулаалгагүй засвар үйлчилгээний байгууламж нь хүйтний улиралд халаалтгүй байна.

7.5.9 Засвар үйлчилгээний байгууламжийн хана, дээврийг дулаан тусгаарлагчтай хийсэн байна.

7.5.10 Хүйтний улиралд усан замын тээврийн хэрэгслийг халаах боломжтой агааржуулагчийн системээр тоноглогдсон усан замын тээврийн хэрэгслийг засвар үйлчилгээний халаалтгүй байгууламжид тусад нь байрлуулна.

7.5.11 Засвар үйлчилгээний байгууламжийн хаягдал ус зайлуулах худгийн ширмэн сараалж торон тагуудыг усан замын тээврийн хэрэгслийг зөөвөрлөж буй хүнд техникийн дугуйнд дайрагдахааргүй суурилуулсан байна.

7.5.12 Засвар үйлчилгээний байгууламжийн дээврийн цас хайлах үед хаалганы өмнө дусаал гоожиж, овгор мөс тогтохоос урьдчилан сэргийлсэн байдлаар түүний дээврийг барьсан байна.

7.5.13 Хүйтэн өвөлтэй бүс нутгуудад засвар үйлчилгээний халаалттай байгууламжийг ашиглана.

7.5.14 Усан замын тээврийн хэрэгслийн өвлийн хадгалалтын үед халаалтын систем нь засвар үйлчилгээний байгууламж дотор 5°C, түүнээс илүү хэмийн дулаанаар хангаж байх ёстой.

7.5.15 Засвар үйлчилгээний байгууламжийн хэмжээ (урт, өргөн, өндөр)-г дараах нөхцөлийг харгалзан тодорхойлно. Үүнд:

7.5.15.1 усан замын тээврийн хэрэгслүүдийг байрлуулахаар өгөгдсөн газрын байршил, хэмжээ;

MNS GOST R 57618-2:2023

7.5.15.2 усан замын тээврийн хэрэгслийг засвар үйлчилгээний байгууламж дотор оруулж байрлуулах, түүнээс гаргахаар сонгож авсан технологи;

7.5.15.3 үйлчлэхээр төлөвлөж буй усан замын тээврийн хэрэгслүүдийн овор хэмжээ, тоо ширхэг.

7.5.16 Засвар үйлчилгээний байгууламж нь маш цөөн тулгуур баганатай байна.

7.5.17 Засвар үйлчилгээний байгууламжийн хаалганы өндөр, өргөн нь хадгалах хамгийн том оврын усан замын тээврийн хэрэгслийн хэмжээнд нийцэж байна.

7.5.18 Засвар үйлчилгээний байгууламж доторх тавиурууд дээр усан замын тээврийн хэрэгслийг байрлуулж хадгалах үед тавиуруудын байршил, үзүүлэлтүүд нь галын аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

7.5.19 Боомтын нутаг дэвсгэрээр усан замын тээврийн хэрэгслийг шилжүүлж зөөвөрлөх хөдөлгөөнийг түүний эзэмшигч /ашиглагч/-ийн автомашины чиргүүл /тоног төхөөрөмж/-өөр эсхүл зогсоол ашиглагчийн машин тоног төхөөрөмжөөр гүйцэтгэнэ.

7.5.20 Усан замын тээврийн хэрэгслийг усанд тавих, уснаас гаргахдаа төмөр замын рельс суурилуулсан тусгай налуу тавцан ашиглах буюу зогсоол ашиглагчийн шилжүүлэн ачих тоног төхөөрөмжөөр гүйцэтгэнэ.

7.5.21 Зам төмөр суурилуулсан тусгай налуу тавцангийн хэмжээ болон ачаалж болох даацын хэмжээ нь усанд тавихаар, эсхүл уснаас гаргахаар төлөвлөж буй усан замын тээврийн хэрэгслийн овор хэмжээ, хүндийн жин ба өргөх буулгах машин тоног төхөөрөмжийн үзүүлэлтүүдэд нийцсэн байна.

7.6 Боомтын агуулахад тавих шаардлага

7.6.1 Боомтын агуулах /цаашид “агуулах” гэх/ -ын барилга, байгууламж нь “Олон нийтийн барилга” БНБД, “Агуулахын барилга “ БНБД -ээр тогтоосон шаардлагыг хангасан байна.

7.6.2 Агуулахуудад хоорондоо үл зохицох материалыг тус тусад нь хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

7.6.3 Агуулахуудын зэрэглэл, бүсүүдийн ангилал буюу тэсэрч дэлбэрэх болон гал түймрийн аюултай хэсгүүд нь Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, MNS 4244:1994 Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага, MNS 4223:1994 Тэсрэх бодис. Техникийн шаардлагад заасны дагуу тэдгээрт хадгалах материалын шинж чанарт нийцсэн байна.

7.6.4 Агуулахын зориулалттай задгай талбайн налуу нь 5 промилле-ээс багагүй, 20 промилле-ээс ихгүй байна.

7.6.5 Боомт доторх бүх талбай, явган хүний зам, тээврийн хэрэгслийн зорчих зам нь хатуу хучилттай байх ба хучилтын төрлийг тогтоохдоо цаг уурын нөхцөл, дотоодын зах зээлд байгаа барилгын материал болон тээврийн хэрэгслийн үзүүлэлтийг харгалзан тогтооно.

7.6.6 Битүү агуулахууд болон албан барилгуудын шалны тэмдэглэгээ нь үерийн усны оргил түвшнээс доошгүй, хэтрүүлэх магадлал 0,5%-5,0% байна. Агуулах болон албан барилгуудын шалны түвшингийн тэмдэглэгээ нь боомтын нутаг дэвсгэрийн тэмдэглэгээнээс доош байх ёсгүй.

7.6.7 Ачигч машин механизм агуулах руу орох, гарахад зориулагдсан өргөгчтэй налуу зам (пандус)-ын налуу өнцгийн дээд хязгаар нь 120 промилле-ээс ихгүй байна.

7.6.8 Агуулахуудын хаалгыг нээх, хаах болон шаардлагатай байрлалд зогсоход аюулгүй, удирдаж ажиллуулахад хялбар, ашиглахад найдвартай тоноглол хэрэгслээр тоногдсон байна.

7.6.9 Агуулахын барилгын хийц, бүтээцийн бүрдэл хэсгийг будах өнгийг MNS 4643:1998 Хөдөлмөр хамгаалал. Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө/ -д нийцүүлэн зураг төсөлд тусгаж төлөвлөсөн байна.

7.6.10 Битүү агуулахын шал болон ачаа ачих буулгах машин, тээврийн хэрэгслүүд орж ачаа ачих, буулгах, агуулахаас ачаа зөөж гаргах, оруулахад зориулагдсан, агуулахын шал, тээврийн хэрэгслийн тэвш хоорондох өндрийн зөрүүд хэрэглэдэг налуу талбайг хатуу, тэгш, гулсдаггүй материалаар бүрсэн байх ёстой ба ус зайлуулах налуу нь 15 промилле -ээс хэтрэхгүй байна.

7.6.11 Хүнд даацын дугуйтай ачигч машин механизм, чирэгч машин механизм болон аккумуляторт тэргэнцэр ажиллахад зориулан агуулахын шалыг асфальт, бетон эсхүл зузаан модон хучилттай байхаар төлөвлөнө. Даралтат хийт зөөлөн дугуйтай машин ашиглах тохиолдолд агуулах нь хатуу хучилттай шалтай байна.

7.6.12 Агуулахын хаалганы тээврийн хэрэгсэл явж өнгөрөх хэсэгт ачигч машин механизм болон ачаа зөөж, тээвэрлэх бусад төрлийн өөрөө явагч машиныг орох хэсэгт хөдөлгөөнд саад болох эд зүйл байх ёсгүй.

7.6.13 Гэрэлтүүлгийн хагарсан эсхүл шатсан гэрлийг солиход аюулгүй ажиллагааг хангах зориулалттай зөөврийн хөнгөн өргөгч механизм (эсхүл өөр төрлийн төхөөрөмж) агуулахад байлгана.

7.6.14 Агуулахын өрөө, тасалгаанд, түүний дээврээс борооны ус зайлуулах хоолойг төлөвлөсөн байна.

7.6.15 Нутаг дэвсгэр, явган хүний зам, тээврийн хэрэгслийн зорчих зам, задгай талбай дээрх ажлын байрны хоногийн харанхуй цагийн гэрэлтүүлэг нь Хүснэгт 1-т заасан шаардлагыг хангасан байна.

1-р хүснэгт- Боомтын нутаг дэвсгэрийн гэрэлтүүлэг

Объект	Хамгийн бага гэрэлтүүлэг /лк/	Гэрэлтүүлэг хэвийн байх хавтгай	Тайлбар
Зам	0,5	Тээврийн хэрэгслээр зорчих түвшинд	-
Авто тээврийн хэрэгсэл болон барилгын машин механизмын зогсоол, нутаг дэвсгэр, ажил гүйцэтгэж буй бүс дэх зам, талбай	2	Гэрэлтүүлж гадаргуугийн түвшинд буй	
Шат, явган хүний гүүрэн гарц	3	Гэрэлтүүлж гадаргуугийн түвшинд буй	
Усан замын тээврийн хэрэгсэлд тоног төхөөрөмж, бүрдэл хэсгийг ачиж, буулгах	10	Хэвтээ	Хүлээн авах, хүлээлгэн өгөх талбайд

7.6.16 Гэрэлтүүлгийн шугам сүлжээнд (6)-д заасантай нийцсэн цахилгааны системийг ашиглана.

7.6.17 Гагнуурын ажлыг ГОСТ 12.3.003 стандартад заасан цахилгаан гагнуурын ажил гүйцэтгэх үед баримтлах Хөдөлмөрийн аюулгүй байдлын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэнэ.

7.7 Боомтын авто замд тавих шаардлага

7.7.1 Авто замын өргөн нь ашиглах тээврийн хэрэгсэл, эсрэг талын тээврийн хэрэгслийн урсгалыг тооцсон хөдөлгөөний эрчим, шилжүүлэн зөөх усан замын тээврийн хэрэгслийн овор хэмжээнд нийцсэн байна. Боомтын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн зорчих зам, явган хүний зам, орц, гарц болон аюултай бүсийн хаалт хашлагыг заасан тэмдэг тэмдэглэгээг суурилуулсан байх ба түүнчлэн шөнийн цагт урьдчилан сэргийлж анхааруулсан мэдээлэл, хаяг, самбарын гэрэлтүүлгийг зохих стандартад нийцүүлсэн байна.

7.7.2 Явган зорчигчдыг гол замын дагуу зорчиход нь зориулж замын нэг талд нь 1,5м-ээс багагүй өргөнтэй явган хүний зам төлөвлөнө. Уг зам нь гол замын хучилтаас дээш 15см-ээс багагүй хэмжээгээр өргөгдсөн байх ба эсхүл бургас тарьсан ногоон зүлгээр тусгаарлагдсан байна. Явган хүний зам нь хатуу хучилттай, ус зайлуулахад зориулагдсан налуутай байна.

7.7.3 Авто замын техникийн нөхцөл байдал нь ЗЗБНБД 31-008-2016 “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлагыг хангасан байна.

7.7.4 Автомашин зогсох талбайг авто замын зорчих хэсгээс тусдаа, тусгайлан зориулсан талбайд байгуулна.

7.7.5 Авто зогсоолын талбайн хэмжээ нь автомашины тоо, төрөлд нийцсэн байна.

7.7.6 Авто тээврийн хэрэгслийн төрөл болон чиргүүл дээрээ тээвэрлэх усан замын тээврийн хэрэгслийн төрлөөс хамааруулан нэг автомашин зогсох зогсоолын талбайн хэмжээг тогтооно. Нэг авто зогсоолын талбайн өргөн дараах хэмжээтэй байна. Үүнд:

7.7.6.1 автомашины өргөн 2,75 м хүртэл байх тохиолдолд 3,50 м;

7.7.6.2 автомашины өргөн 2,75 м-ээс илүү байх тохиолдолд 4,50 м.

7.7.7 Цул резинэн дугуй бүхий ачигч машин механизм, чирэгч машин механизм болон аккумуляторт тэрэгний ажиллах нөхцөлийг хангах зорилгоор зам талбайн хучилт нь асфальт, бетон эсхүл зузаан модон банзаар хийсэн байна.

7.8 Багийн гишүүд болон үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний цогцолбор

7.8.1 Багийн гишүүд болон үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний цогцолбор нь СП 42.13330-ийн [4], [7]-д заасан “хот ба хөдөөгийн суурин газруудын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа тэдгээрийн эдийн засаг-газар зүй, нийгэм, үйлдвэрлэл, түүх архитектурын болон байгалийн нөөцийн бодит хүртээмжийг үнэлэхээс эхлэх зайлшгүй шаардлагатай...” гэсэн болон “нутаг дэвсгэрийг сонгохдоо архитектур төлөвлөлтийнх нь шийдвэрийн хувилбаруудыг харьцуулсны үндсэн дээр гүйцэтгэх үүрэг зориулалтынх нь дагуу түүнийг үр ашигтайгаар ашиглах боломжийг тооцон, техник-эдийн засгийн болон эрүүл ахуй халдвар хамгааллын үзүүлэлтүүд, түлш эрчим хүч, нутаг дэвсгэрийн ба усны нөөцүүд, хүрээлэн буй байгаль орчны нөхцөл байдлыг ирээдүйд байгалийн эсвэл өөр бусад нөхцөл байдлын улмаас өөрчлөгдөх хэтийн төлөвийг харгалзан сонгоно...”, мөн “орон сууцны болон нийтийн – ажил хэргийн бүсийг барилгажуулахад баримтлах үзүүлэлтүүд”-д заасан “орон сууцны барилгуудын хоорондох болон орон сууцны барилгууд ба олон нийтийн барилгууд, мөн үйлдвэрийн барилга байгууламжуудын хоорондох зайг агаарын солилцоо, гэрэлтүүлгийн норм, галын аюулаас сэргийлэх тооцоо судалгааны үндсэн дээр тодорхойлно...” гэсэн шаардлагыг тус тус хангасан байна.

7.8.2 Усан замын тээврийн хэрэгслийн зогсоол /цаашид “зогсоол” гэх/ -ууд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

7.8.2.1 усны ямар ч түвшний үед багийн гишүүд, зорчигчид усан замын тээврийн хэрэгсэлд аюулгүй сууж, буухад болон ачаа тээшийг аюулгүй ачиж, буулгахад боломжтой байх;

7.8.2.2 зогсоол тус бүр дээрх, усан замын тээврийн хэрэгслийг аргамжиж бэхлэх бэхэлгээний шон, дэгээт хэрэгслийн байрлал нь тухайн зогсоолд байрлуулахаар тооцоолсон төрлийн усан замын тээврийн хэрэгслийг усны ямар ч түвшний үед аргамжиж бэхлэх үед хүмүүс болон усан замын тээврийн хэрэгслийн аюулгүй байдлыг хангаж байх ёстой;

7.8.2.3 зогсоолуудын байршил, зохион байгуулалт нь усан замын тээврийн хэрэгслийг зогсоолд аюулгүй ойртуулах болон зогсоолоос хөдөлгөхөд зайлшгүй шаардлагатай маневр хийх нөхцөлийг усан замын тээврийн хэрэгслийн жолоодогчдод бүрдүүлсэн байна;

7.8.2.4 зогсоолуудад хүрэх шатны өргөн, гүүрнүүдийн тоо ширхэг нь зогсоолд хүрч очих болон зогсоолоос буцах хамгийн олон боломжит хүний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан байна.

7.8.3 Агаарын /хийн/ дэртэй усан замын тээврийн хэрэгсэл болон аялал зугаалгын усан замын тээврийн хэрэгсэлд тусад нь зогсоол төлөвлөх шаардлагатай.

7.8.4 Зогсоолын байгууламж, тоног төхөөрөмж, хэрэгслүүд нь 7.4-т заасан шаардлагыг хангасан байна.

7.8.5 Дамжин орох, гарах гүүрнүүд болон налуу зам нь 1:8-аас хэтрэхгүй налуу байна.

7.8.6 Зогсоол тус бүр дээрх, усан замын тээврийн хэрэгслийг аргамжиж бэхлэх зориулалттай бэхэлгээний цутгамал ширмэн шон, дэгээт цул шон хэрэгслийг цаг агаарын ямар ч нөхцөлд, усны ямар ч түвшний үед усан замын тээврийн хэрэгслийн бэхэлгээний найдвартай байдлыг хангаж байхаар, усан замын тээврийн хэрэгсэл дээрх бэхэлгээний тоноглол, хэрэгслийн байршилтай уялдуулан суурилуулна.

7.8.7 Эрэг дагуух зогсоолыг аврах цагаригуудаар хангасан байна.

7.8.8 Мэдээлэл, лавлагааны үйлчилгээ үзүүлэх, цэвэрлэгээний ажил үйлчилгээний тоног төхөөрөмж болон тэдгээрийн ашиглалтын үйл ажиллагаа нь тухайн төрлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд тавих шаардлага, техникийн тусгай дүрэм, журмын шаардлагад нийцсэн байна.

7.8.9 Боомтод эмнэлгийн анхны тусламж үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон өрөө, тасалгаатай байна.

7.8.10 Боомтын олон нийтийн үйлчилгээний барилга, байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй болон хүн амын дундах хөдөлгөөний бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байна. Үүнд:

7.8.10.1 барилга, байгууламжийн хийц загвар /архитектур/-ын орчны онцлог нь хүнд хэт ядаргаагүй, гэмтэх, бэртэх, шархдах, тахир дутуу болох гэх мэт ослоос сэргийлэх, зайлсхийх боломжтой байх;

7.8.10.2 эрсдэл бүхий газар, бүсийг цаг тухайд нь мэдрэх, таних, хариу арга хэмжээ авах боломжтой байх;

7.8.10.3 хүлээн авч мэдрэх, хариу арга хэмжээ авахад хэцүү замын хөдөлгөөний огтлолцлын хэсгүүдээс зайлсхийх;

7.8.10.4 бодит аюултай бүсүүдийн талаар анхааруулж сэрэмжлүүлэх;

7.8.10.5 эрсдэлтэй нөхцөл байдлыг өдөөгч орчныг хүлээн авч мэдрэх хуурмаг нөлөөллүүдийг үгүй болгох;

7.8.10.6 өргөх, зөөвөрлөх тоног төхөөрөмж, усан замын тээврийн хэрэгсэлд суух, буухад зориулсан тоног төхөөрөмж ашиглах боломж.

7.9 Боомтын технологийн цогцолборын тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд тавих шаардлага

7.9.1 Боомтын технологийн цогцолборын объектуудыг газрын гадаргуугийн болон гүний ус, залгаа орших нутаг дэвсгэр, агаар мандлыг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, Боомтын технологийн цогцолборын экологийн аюулгүй байдлыг бүхэлд нь хангах тоног төхөөрөмж, хэрэгслүүдээр тоноглогсон байна.


7.9.2 Боомтын технологийн цогцолборын тоног төхөөрөмж нь ашиглалтын баримт бичигт урьдчилан заасан шаардлагуудыг мөрдөн шилжүүлэн ачих эргийн болон хөвөгч байгууламжийн технологийн шугамын бүрэлдэхүүнд ашиглах технологийн цогцолборын дэд бүтцийн объектууд, олборлох шилжүүлэн тээвэрлэх цогцолбор ба зорчигч тээврийн иж бүрэн тохижуулсан зогсоол /терминал/-уудыг ашиглалтад оруулах, угсрах, (задлах) үеийн аюулгүй байдлыг хангасан байна.

7.9.3 Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд тавих ерөнхий шаардлага нь ГОСТ Р 1.2.032-1.003.16 стандартад нийцсэн байна.


ТӨГСӨВ.

А хавсралт
(Мэдээллийн)

**Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн боомтын зохион байгуулалтын
болон үйл ажиллагааны схем**



**А.1-р зураг – Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн боомтын
зохион байгуулалтын схем**



А.2-р зураг - Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн боомтын үйл ажиллагааны схем

Ном зүй

- (1) СанПиН 2.2.1/2.1.1.1200-03 Эрүүл ахуй, халдвар хамгааллын бүс ба үйлдвэр, байгууламж болон бусад объектуудын эрүүл ахуй, халдвар хамгааллын ангилал
- (2) “Барилга, байгууламжийн аюулгүй байдалд тавих техникийн шаардлага” 2009 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Холбооны хууль № 384-ФЗ
- (3) НПБ 105-95 Тэсэрч дэлбэрэх болон гал түймрийн аюултай барилга, байгууламжийн зэрэглэлийг тодорхойлох
- (4) “Гал түймрийн аюулгүй байдалд тавих техникийн шаардлага” 2008 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн Холбооны хууль № 123-ФЗ
- (5) Барилга, байгууламжийн гал түймрийн аюулгүй байдал (2002 сарын 7 дугаар сарын 19-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан) СНиП 21-01-97
- (6) Цахилгаан тоног төхөөрөмжийн суурилуулалтын дүрэм. Долдугаар хэвлэл (ОХУ-ын Эрчим хүчний сайдын 2002 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн тушаал № 204 - аар батлагдсан)
- (7) СНиП 31-06-2009 Олон нийтийн үйлчилгээний барилга, байгууламж